

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 31-ны өдөр

№ 17/08

Улаанбаатар хот

Эрх зүйн баримт
бичгийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.4 дэх заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.10 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 145 тоот тогтоолоор батлагдсан Компанийн засаглалын кодекс, Монос Хүнс ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6 дугаар заалт зэргийг үндэслэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн 04/05 тоот тогтоолын хавсралтаар батласан “Монос хүнс ХК-ийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Монос хүнс ХК-ийн “Залгамж халааны бодлого”-ыг Хавсралт №01-ээр, “Мэдээллийн үйл ажиллагааны журам”-ыг Хавсралт №02-оор тус тус баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Монос хүнс ХК-ийн эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Х.АНАНД

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын
2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн
.../... тоот тогтоолын 2 дугаар хавсралт

МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

[КОМПАНИЙН ХЭРЭГЦЭЭНД]

Баримт бичгийн төрөл:	Журам
Хамрах хүрээ:	Нийт ажилтнууд
Хувийг хадгалах:	ТУЗ НБД, Захирлын туслах
Баталсан:	Х.Ананд /ТУЗ-ийн дарга/
Хуудасны тоо:	.../... хуудас
Батлагдсан огноо:	2023 оны 08 дугаар сарын 31

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ХОЁР. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

ГУРАВ. ХУГАЦААТ ТАЙЛАНГ МЭДЭЭЛЭХ

ДӨРӨВ. ТУХАЙ БҮР НИЙТЭД МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЭЛ

ТАВ. НИЙТЭД МЭДЭЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЯНАХ

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Монос Хүнс ХК-иас /цаашид “компани” гэх/ хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагч, олон нийтэд болон эрх бүхий байгууллагууд компанийн талаарх үнэн зөв мэдээллийг тогтмол хүргэх, Компани нь хууль тогтоомж, дүрэм журамд заасан болон бусад ач холбогдол бүхий мэдээллийг нээлттэй болгох, хувьцаа эзэмшигчдийн зүгээс компанийг удирдах үйл ажиллагаанд оролцох эрхээ зохистойгоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд оршино.
- 1.2. Энэхүү журмыг “Монос хүнс ХК-ийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах үүднээс Монгол улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Монголын хөрөнгийн биржээс баталсан “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам” зэрэг зохицуулагч байгууллагын журам, заавар болон компанийн дүрэм, дотоод журамд нийцүүлэн боловсруулсан болно.
- 1.3. Энэхүү журамд орсон дараах нэр томъёог доорх утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.3.1. **Мэдээллийг нээлттэй болгох:** Компани нь холбогдох хууль тогтоомж болон дүрэм журамд заасан зохих мэдээллийг эрх бүхий байгууллагууд, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид биечлэн болон бусад аргаар танилцаж болох нөхцөл бүрдүүлэхийг;
 - 1.3.2. **Олон нийтэд нээлттэй хүргэх мэдээлэл:** Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, зохицуулагч байгууллагуудаас гаргасан журмын дагуу хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагч, харилцагч, бусад оролцогч талуудад мэдээлэл авах, шийдвэр гаргахад зориулан компани тайлант хугацааны болон шаардлагатай мэдээллийг өөрийн цахим талбар болон Монголын хөрөнгийн биржийн цахим талбар, бусад сувгаар тогтмол нээлттэйгээр мэдээлэх мэдээллийг;
 - 1.3.3. **Дотоод мэдээлэл эзэмшигч:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77-р зүйлд заасан компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтан, тэдгээрийн холбогдох этгээд, мөн албан үүргээ хэрэгжүүлэх, гэрээ, хэлцлийн бэлтгэл болон түүнийг байгуулах, гүйцэтгэх үе шатанд дотоод мэдээллийг олж авсан этгээд болон тэдгээрийн холбогдох этгээдийг;

ХОЁР. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 2.1. Компани нь мэдээлэл нээлттэй болгох үйл ажиллагаанд дараах зарчмыг мөрдлөг болгоно. Үүнд:
 - Тухайн мэдээллийн ач холбогдол, компанийн бизнест нөлөөлөх байдлаас хамааруулан мэдээллийг тогтмол давтамжтай хүргэж байх;
 - Холбогдох хууль, дүрэм, журамд заасан мэдээллийг эрх бүхий этгээд, хувьцаа эзэмшигчдэд хүргэх хүртээмж, ач холбогдолтой нь уялдуулан тогтсон цаг хугацаанд нь боловсруулж, нийтэд хүргэж байх;
 - Компанийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий этгээдэд тэгш хүртээмжтэй байх;
 - Үнэн зөв байх, тодорхой, ойлгомжтой байх;
 - Агуулгын хувьд хоёрдмол санаагүй байх;
 - Компанийн бизнесийн эрх ашгийг хамгаалах болон нээлттэй байх зарчмын зохистой тэнцвэрийг хангасан байх;
 - Хувьцаа эзэмшигчид мэдвэл зохих өөрийн үйл ажиллагааны доголдол, дутагдлыг нууж хаахгүй байх;
 - Бусад мэдээллийн нээлттэй, ил тод байх үндсэн зарчмууд.

ГУРАВ. ХУГАЦААТ ТАЙЛАНГ МЭДЭЭЛЭХ

- 3.1. “Хугацаат тайлан” гэж компаниас хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, олон нийтэд компанийн санхүү үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэх зорилгоор гаргасан жил, хагас жил, улирлын үйл ажиллагааны тайланг хэлнэ.
- 3.2. Компани нь Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт хүснэгтэд заасан асуулгын дагуу бэлтгэн жилийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор, хагас жил, улирлын тайланг дараа сарын 20-ны

өдрийн дотор зохицуулагч байгууллагад цаасаар хүргүүлж, цахим талбарт нээлттэйгээр байршуулан мэдээлэх ба үйл ажиллагааны тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- 3.2.1. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл
- 3.2.2. Удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын өөрчлөлт, томилгоо, компанийн засаглалын талаарх мэдээлэл
- 3.2.3. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл
- 3.2.4. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл
- 3.2.5. Ногдол ашгийн талаарх мэдээлэл
- 3.2.6. Цалин урамшууллын мэдээлэл
- 3.2.7. Зах зээлийн эрсдлийн мэдээлэл
- 3.2.8. Нийгмийн хариуцлагын мэдээлэл
- 3.2.9. Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагааны тайлан, мэдээлэл
- 3.2.10. Бусад шаардлагатай мэдээлэл
- 3.3. Компани Монголын хөрөнгийн биржийн болон өөрийн албан ёсны вебсайтаар дамжуулан тайлан мэдээллийг ил тод байршуулан мэдээлнэ.
- 3.4. Олон нийтэд түгээвэл зохих мэдээлэлд компанийн ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр олон нийтэд хүргэх нь зүйтэй хэмээн үзсэн компанийн үйл ажиллагаа, хувьцааны үнэ ханшид нөлөөлөх боломжтой мэдээллүүдийг хамааруулна. Эдгээр мэдээллийг олон нийтэд тараах хугацаа, арга замыг компанийн ТУЗ эсвэл Гүйцэтгэх удирдлага тогтооно.
- 3.5. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээллийг олон нийтэд хүргэж болно. *(тухайлбал: компанийн нэвтрүүлж буй шинэ бараа үйлчилгээний тухай, компанид болсон онцлох үйл явдлын тухай, үйл ажиллагааны тайлан гэх мэт)* Эдгээр мэдээллийг компанийн Гүйцэтгэх удирдлага, холбогдох алба, хэлтсүүд хариуцан олон нийтэд хүргэнэ.
- 3.6. Байгууллагын нууцын зэрэглэлд орсон мэдээллийг шүүх, цагдаа, татвар зэрэг төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд мэдээллэхгүй.

ДӨРӨВ. ТУХАЙ БҮР НИЙТЭД МЭДЭЭЛЛЭХ МЭДЭЭЛЭЛ

- 4.1. Компанийн ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтанд нөлөө үзүүлэхүйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ тухай мэдээллийг тухай бүр энэ журамд заасны дагуу олон нийтэд мэдээлнэ.
- 4.2. Компаниас тухай бүр нийтэд хүргэх мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна. Үүнд:

Санхүүгийн мэдээлэл

- 4.2.1. Компанийн хөрөнгө, өр төлбөр хувьцаат капитал болон үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ хэлцэл байгуулах;
- 4.2.2. Компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг дуусгавар болгох, цуцлах;
- 4.2.3. Компани хөндлөнгийн аудитын байгууллагатай байгуулсан гэрээ нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
- 4.2.4. Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл;
- 4.2.5. Компанийн үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнгийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр бусад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах, компани төлбөрийн чадваргүй болох;
- 4.2.6. Компанийн толгой, охин болон хараат компани өр төлбөрөө төлөх санхүүгийн чадваргүй болох
- 4.2.7. Компанийн өрийг хувьцаагаар солих шийдвэр гарах;

Санхүүгийн бус мэдээлэл

- 4.2.8. Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон;
- 4.2.9. Компанийн бизнесийн үйл ажиллагааны зарим хэсгийг охин, хараат компанид болон бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл хязгаарлах болсон;
- 4.2.10. Компани үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулах;
- 4.2.11. Үндсэн болон шинэ бүтээгдэхүүнд зориулан тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах эрх, барааны тэмдэг эзэмших болон цуцлагдах;
- 4.2.12. Компанийн оноосон нэр, үндсэн захиргаа болон толгой компанийн оршин байх хаяг байршил өөрчлөгдсөн;

- 4.2.13. Компани салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах болсон талаарх мэдээлэл;
- 4.2.14. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад орсон өөрчлөлт.
- 4.3. Компанийн энэ журмын 4.2-т заасан болон хууль тогтоомжид ил болгохоор заасан бусад мэдээлэл өөрчлөлт орсоноос хойш ажлын 2 өдөрт багтаан нийтэд мэдээллэх үүрэгтэй.

ТАВ. НИЙТЭД МЭДЭЭЛЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАХ

- 5.1. Энэ журамд заасан хугацаат тайлан болон тухай бүр мэдээллэх мэдээллийг бэлтгэх, өөрийн цахим хуудсанд байршуулах, зохицуулах байгууллагад хүргүүлэх, бусад талбар, сувгаар мэдээлэх үүргийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга холбогдох албан тушаалтны хамт гүйцэтгэнэ.
- 5.2. Журмын 5 дугаар зүйлийн 5.1-д заасан тайлан мэдээлэл нь монгол хэлээр байх ба шаардлагатай тохиолдолд гадаад хэлээр бэлтгэн мэдээлнэ.
- 5.3. Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь компаниас мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлж байгаа эсэхэд хяналт тавьж, гарсан үр дагаврыг хариуцна.
- 5.4. Аливаа мэдээллийн үнэн зөвийг уг мэдээг боловсруулсан болон хянасан албан тушаалтан хариуцна.
- 5.5. Мэдээллийг нээлттэй, ил тод болгохдоо нууц, дотоод мэдээллийг хууль бусаар, компанийн ашиг сонирхлын эсрэг ашиглах явдлаас Гүйцэтгэх удирдлага урьдчилан сэргийлэх үүрэгтэй.
- 5.6. Компани нууцлалын шинжтэй баримт бичгийг зохицуулагч байгууллагууд руу илгээхдээ түүний нууцыг хадгалах, анхаарах шаардлага бүхий албан бичгийн хамтаар илгээнэ.
- 5.7. Компанийн хувьцаа эзэмшигч мэдээлэл авах хүсэлтээ албан бичгээр болон цахим шуудангаар ирүүлсэн тохиолдолд хууль журмын дагуу нийтэд мэдээлэх боломжтой, нууцын ангиллын биш, энэ журмаар хориглоогүй холбогдох мэдээллийг албан бичгээр болон цахим шуудангаар ажлын 5-10 хоногт багтаан ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хуулбарлан өгөх, хүргэх үүргийг хүлээнэ.
- 5.8. Олон нийтэд нээлттэйгээр хүргэх зорилгоор компанийн албан ёсны цахим талбарт байршуулсан мэдээллийг 3 жилийн хугацаатай байршуулаад архивлах ба мэдээллийн цаасан эх хувийг компанийн “Баримт бичиг боловсруулах, архивлах журам”-д заасны дагуу бүртгэж хадгална.
- 5.9. Энэхүү журмаар зохицуулаагүй үйл ажиллагааг холбогдох хууль, зохицуулагч байгууллагаас гаргасан журам, дүрэмд зааснаар зохицуулна.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 6.1. Компаниас ил болгосон мэдээллийг зүй бусаар ашигласан, компанийн нэр хүндийн эсрэг хууль бусаар ашигласан этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгүүлэхээр төрийн эрх бүхий байгууллагад хандана.
- 6.2. Энэхүү журмыг зөрчсөн, зөвшөөрөгдсөнөөс бусад мэдээллийг бусдад тараасан ажилтны үйлдэл нь компанид эд хөрөнгийн хохирол учруулсан эсэхийг үл харгалзан Хөдөлмөрийн тухай хууль, дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

---oOo---